



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/793 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор зохион байгуулагдаж буй “Иргэдийн баяр-Хүрээ цам даншиг” наадамд оролцож, дүүргийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, ардын авьяастан, уран бүтээлчдийн тоглолтыг зохион байгуулсугай.

2. Наадамд оролцогчдыг удирдлага, арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Ажлын хэсэг (Х.Цогцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Х.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
11.13.1 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Х.Цогцэцэг

Г.Дагвадорж

Л.Санжийжамц

Б.Отгонжаргал

Ц.Мягмарсүрэн

Д.Хүрэлбаатар

Н.Нямзав

Б.Батзориг

Г.Тэмүүлэн

Б.Алтанцоож

Д.Ууганбаатар

Засаг даргын орлогч

Дүүргийн менежер

Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн Захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Биеийн тамир, спортын хорооны дарга

Соёлын ордны захирал

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг
дэмжих төвийн захирлын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичиг:

Б.Цогжавхлан

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга